



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**
Гүйцэтгэлийн аудитын алба



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа
мэргэжлийн боловсролын болон их дээд
сургуулиудын үйл ажиллагааны үр дүн”-д
хийсэн аудитын тайлан**

АУДИТЫН КОД: ДОА-2020/05/-ГА

Чойбалсан хот 2020 он



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер В.Цэнгэлмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Дэлгэрмаа
Аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn
Гэрээт аудитор Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4204, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН БОЛОН ИХ ДЭЭД СУРГУУЛИУДЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	6
1.1.Үйл ажиллагааны бодит үр дүн буюу төгсөгчдийн ажил эрхлэлтэд анхаарах шаардлагатай байна.	6
1.2.Хүний нөөцийн бодлого, хөгжлийн хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт хангалтгүй байна.....	10
БҮЛЭГ 2. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	19
2.1.Сургалтын хөтөлбөр зохих стандартыг хангаж байна.....	19
2.2.Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний материаллаг орчин хангалттай хэмжээнд бүрдсэн байна.	21
2.3.Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байна.....	23
БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ, САНХҮҮГ ҮР АШИГ, АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.	25
3.1.Төсвийн орлогыг бодитой тооцож төлөвлөөгүй байна.	25
3.2.Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.	29
Холбогдох байгууллагын санал:	35
Саналд өгсөн тайлбар:	37
ДҮГНЭЛТ:	37
ТӨЛБӨРИЙН АКТ.....	
АЛБАН ШААРДЛАГА.....	
ЗӨВЛӨМЖ:	38
ТУШААЛ:	40



Товчилсон үгийн тайлбар

ГА	Гүйцэтгэлийн аудит
ДОА	Дорнод аймаг
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БСШУ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ДИС	Дорнод Их сургууль
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ПК	Политехник коллеж
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй



Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Үр дүнгийн гэрээний харьцуулсан үнэлгээ	6
Хүснэгт 2	"Улсын хэмжээнд ажилгүй иргэдийн боловсролын түвшин"	7
Хүснэгт 3	"Ажлын байрны судалгаа" /ДИС/	10
Хүснэгт 4	"ДИС-ийн албан хаагчдын мэргэжил, боловсролын судалгаа" /ДИС/	11
Хүснэгт 5	"Ажлын байрны судалгаа" /ПК/	13
Хүснэгт 6	"Дорнод ПК-ийн албан хаагчдын мэргэжил, боловсролын судалгаа"	14
Хүснэгт 7	"Ажлын байрны тодорхойлолтын судалгаа" /ПК/	15
Хүснэгт 8	"Ажлын байрны судалгаа" /МСҮТ/	17
Хүснэгт 9	"Дорнод Их сургуулийн 2018-2020 оны хичээлийн жилийн туслах үйл ажиллагааны судалгаа"	26
Хүснэгт 10	"Орлогын төсвийн санал, төлөвлөгөө, гүйцэтгэл"	27
Хүснэгт 11	"Орлогын төсвийн санал, төлөвлөгөө, гүйцэтгэл"	28
Хүснэгт 12	"Төсвийн гүйцэтгэл"	33

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	"Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, боловсролын зэргээр 2019" /ДИС/	8
Дүрслэл 2	"Төгсөгчдийн ажил эрхлэлт, хөтөлбөр тус бүрээр" /ДИС/	9
Дүрслэл 3	"Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, мэргэжлийн салбараар 2017-2020 он /МСҮТ/	10
Дүрслэл 4	ДИС-ийн багш, ажилтнуудын ажилласан жил, боловсролын судалгаа	12
Дүрслэл 5	ДИС-ийн Санал асуулгын дүн	12
Дүрслэл 6	ДИС-ийн Санал асуулгын дүн	13
Дүрслэл 7	"Дорнод ПК-ийн багш, ажилтнуудын боловсрол, ажилласан жилийн судалгаа"	15
Дүрслэл 8	Дорнод ПК-ийн санал асуулгын дүн	16
Дүрслэл 9	Дорнод ПК-ийн санал асуулгын дүн	16
Дүрслэл 10	"МСҮТ-ийн багш, ажилтнуудын боловсрол, ажилласан жилийн судалгаа"	17
Дүрслэл 11	"МСҮТ-ийн санал асуулгын дүн"	18
Дүрслэл 12	"МСҮТ-ийн санал асуулгын дүн"	18
Дүрслэл 13	"Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл"	25
Дүрслэл 14	Төсвийн зардлын гүйцэтгэл нэр төрлөөр	29
Дүрслэл 15	Төсвийн зардлын гүйцэтгэлийн нийт зардалд эзлэх хувь	30
Дүрслэл 16	Төсвийн зардлын гүйцэтгэл нэр төрлөөр	32



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторов 2019 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын төлөвлөгөө батлах тухай” тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

“Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн боловсролын болон их дээд сургуулиудын үйл ажиллагааны үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Мэргэжлийн боловсролын болон их дээд сургуулиудын удирдлага, зохион байгуулалт үр дүнтэй эсэх,
- Мэргэжлийн боловсролын болон их дээд сургуулиудын боловсрол олгох үйлчилгээний зорилт, зорилго хангагдаж байгаа эсэх,
- Мэргэжлийн боловсролын болон их дээд сургуулиудын орлогын төвлөрүүлэлт, хөрөнгө, санхүүгийн зарцуулалт үр нөлөөтэй эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Дорнод их сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийн 2019 оны үйл ажиллагаа, хүний нөөц, санхүү, дотоод болон хөндлөнгийн хяналтын баримт материалыг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, санал асуулга, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх, ажиглалт хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Я.Зориг, С.Энхбаатар, гэрээт аудитор Б.Оюунхэрлэн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын төлөвлөгөөг 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлуулж, талбарын ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн гүйцэтгэж, тайланг холбогдох газруудад 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдөр хүргүүллээ.



БҮЛЭГ1. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН БОЛОН ИХ ДЭЭД СУРГУУЛИУДЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

1.1. Үйл ажиллагааны бодит үр дүн буюу төгсөгчдийн ажил эрхлэлтэд анхаарах шаардлагатай байна.

Байгууллагын зорилго, зорилтыг тодорхойлох, түүний хэрэгжилтийг тайлагнах баримт бичиг нь тухайн байгууллагын гүйцэтгэлийн /хуучнаар үр дүнгийн/ төлөвлөгөө байхаар шинэчлэгдэн батлагдсан Төрийн албаны тухай хуулийн 54.1¹ дэх хэсэгт заасан байна.

Уг хуулийг 2019 оны эхнээс мөрдөхөөр заасан ч Дорнод их сургууль, Политехник коллеж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирлууд нь 2019 онд үр дүнгийн гэрээ, 2020 оноос гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж ажилласан байна.

Дорнод их сургууль

Захирлын БСШУС-тай 2019 онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт 88.0 хувьтай дүгнэгдсэн нь аудитын явцад бодит гүйцэтгэлийг тулган баталгаажуулахад гарсан үнэлгээтэй адил байна.

ДИС-аас 2017-2024 он хүртэл хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд төлөвлөсөн нь хэрэгжилтийг бүрэн үнэлэх хугацаа нь болоогүй байна. Харин өмнөх 2014-2017 оны стратеги төлөвлөгөө нь 4 үндсэн зорилгын хүрээнд төлөвлөгдөж, биелэлтийг 75.0 хувьтай үнэлсэн байна. (Хүснэгт №1.)

Политехник коллеж

Захирлын ХНХС-тай 2019 онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт 88.9 хувьтай дүгнэгдсэн боловч аудитын явцад бодит гүйцэтгэлийг тулган баталгаажуулахад 81,0 хувьтай байна. (Хүснэгт №1)

Мөн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг 2015-2018 оныг хамруулан баталсан боловч, хэрэгжилт, биелэлтийг тайлагнаагүй, дараа оны стратеги төлөвлөгөө батлуулаагүй байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв

Захирлын 2019 оны үр дүнгийн гэрээг 99,4 хувьтай тайлагнаж, ХНХС-ын үнэлгээ 86.4 хувь, аудитын явцад бодит гүйцэтгэлийг тулган баталгаажуулахад 85.2 хувьтай байна. (Хүснэгт №1.)

Мөн тус сургуулийн стратегийг 2015-2019 оныг хамруулан 8 зорилтын хүрээнд төлөвлөсөн нь 71.9 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 1. “Үр дүнгийн гэрээний харьцуулсан үнэлгээ”

Баримт бичгийн нэр	Байгууллагын өөрийн үнэлгээ	ТЕЗ-ийн үнэлгээ	Аудиторын үнэлгээ
Дорнод их сургууль	91.0	88.0	88.0
Дорнод Политехник коллеж	88.5	88.9	81.0
МСҮТ	99.2	86.4	85.2

¹ 54.1. “Төсвийн шууд захирагч тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан баталж, жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ.”



Сургуулиуд нь үр дүнгийн гэрээний биелэлтийг тайлагнахдаа хэрэгжүүлсэн арга хэмжээг илтгэх хуудсанд дэлгэрэнгүй тайлагнаж байгаа ч Политехникийн коллеж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолын 4.6² дахь заалтын дагуу хүрсэн үр дүн, чанарын үзүүлэлтийг тодорхой тусгаагүй байгаа нь гүйцэтгэл дутуу, зөрүүтэй үнэлэгдэх шалтгаан болж байна.

Мөн холбогдох чиглэлийн яамдаас сургуулиудын захирлын үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээг жагсаалт байдлаар гаргаж байгаа нь учир дутагдалтай байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээ нь тогтоолын 4.4-т “Төсвийн шууд захирагч тухайн жилийн зорилтот түвшинд хүрч чадаагүй зорилт, арга хэмжээний шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, эрх бүхий байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн цаашид үргэлжлүүлэх шаардлагатай арга хэмжээг дараа жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.” гэсэн заалтын дагуу ирэх оны төлөвлөгөөг боловсруулахад чухал ач холбогдолтой юм.

Сургуулиудын үйл ажиллагааны гол зорилт нь чадвартай боловсон хүчнийг хөдөлмөрийн зах зээлд нийлүүлж, төгсөгчид нь ажлын байраар хангагдахад оршино.

Улсын хэмжээнд 2019 онд ажилгүйдлийн түвшин 8.1 хувь байгааг боловсролын түвшнээр авч үзэхэд тодорхой мэргэжил эзэмших түвшний буюу техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд болон дээд боловсролтой ажилгүй хүмүүс нийт ажилгүйчүүдийн 64.3 хувь байна.

Хүснэгт 2. “Улсын хэмжээнд ажилгүй иргэдийн боловсролын түвшин” (%)

Боловсролын түвшин	2018	2019
Боловсролгүй	1.7	3.9
Бага	3.0	4.9
Суурь	8.4	10.7
Бүрэн дунд	18.1	16.2
Техникийн болон Мэргэжлийн	29.7	31.6
Тусгай мэргэжлийн дунд	4.8	4.5
Дипломын дээд	33.2	2.3
Бакалаврын дээд		25.7
Магистр ба түүнээс дээш	1.1	0.2
	100.0	100.0
Бүгд (тоогоор)	105 614	105 139

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс 2019 оны ажиллах хүчний судалгааны дүнг танилцуулахдаа: “Төгсөгчдийн 70.2 хувь нь хөдөлмөр эрхэлж, 12.1 хувь нь ажилгүй, 17.7 хувь нь эдийн засгийн идэвхгүй төлөвт байна. Үүнээс их, дээд сургууль төгсөгчдийн 75.2 хувь нь, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчдийн 62.3 хувь нь тус тус хөдөлмөр эрхэлж байна.” гэж дүгнэсэн байна.

Дорнод аймгийн хэмжээнд ажилгүйдлийн дундаж түвшин 7.0 хувьтай байгаагаас хот, суурин газрын хүн амын хувьд 9.8 хувь буюу улсын дунджаас 1.7 пунктээр

² 4.6. Төлөвлөгөөний биелэлтийн тайланд тухайн зорилт, арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхой тусгах бөгөөд мэдээллийн үнэн, зөв байдлыг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцна.




дээгүүр, харин хөдөө орон нутгийн хувьд 7.4 хувь буюу улсын дунджаас 0.7 пунктээр доогуур байна.

Дорнод их сургууль

Тус сургуулийн хувьд 2017-2019 онд дунджаар төгсөгчдийн 70.0 хувь нь ажлын байраар хангагдсан гэсэн статистик мэдээлэл гарсан нь улсын дундажтай адил хэмжээнд байна.

Үүнээс 2017 онд 58.0 хувь, 2018 онд 80.0 хувь, 2019 онд 72.0 хувьтай байгаа бөгөөд 2019 онд нийт 109 оюутан төгссөнөөс 34 нь магистр, 75 нь бакалаврын хөтөлбөрөөр төгссөн байна.

Дүрслэл 1. “Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, боловсролын зэргээр 2019”



Ажлын байраар хангагдсан байдал нь магистрын төгсөгчид 100 хувь, бакалаврын төгсөгчид 72 хувь байна. Бакалаврын төгсөгчдийн 52 хувь мэргэжлээрээ, 20 хувь мэргэжлийн бус ажил эрхэлж, 4 хувь дэвшин суралцаж, 24 хувь нь ажил хөдөлмөр эрхлээгүй байна.

Бакалаврын хөтөлбөрөөр сурч төгссөн оюутнуудыг ажлын байраар хангагдсан байдалд шинжилгээ хийж үзэхэд (Дүрслэл 2) Багш, бага ангийн боловсрол, Багш, сургуулийн өмнөх насны боловсрол, Нягтлан бодох бүртгэлийн 2.5 жилийн эчнээгийн хөтөлбөр, Урлагийн боловсрол, Мэдээллийн технологи, Газрын тосны инженерийн өдрийн ангийн хөтөлбөрөөр төгсөгчид ажлын байраар бүрэн хангагдсан байгаа нь зах зээл дээрх тухайн чиглэлийн мэргэжлийн ажлын байрны эрэлт, хэрэгцээ их, мөн ажил хийж байгаа иргэд мэргэжил эзэмшихээр суралцсантай холбоотой байна.

Багш, сургуулийн өмнөх насны боловсрол /5 жил эчнээ/, Нягтлан бодох бүртгэл /5 жил эчнээ/, Багш биеийн тамирын боловсрол, Багш, бага ангийн боловсрол мэргэжлээр төгсөгчдийн 33,3-50,0 хувь, Багш, гадаад хэлний боловсрол, Гадаад хэлний орчуулга мэргэжлээр төгсөгчдийн 66,6 хувь нь ажлын байраар хангагдсан байгаа нь тухайн мэргэжлээр зах зээл дээрх ажлын байрны эрэлт хэрэгцээ бага, эсвэл тухайн төгсөгчийн мэргэжлээрээ ажиллах сонирхол бага, ажил олгогчдоос тавих шалгуур өндөр, төгсөгчид хувийн ажил хөдөлмөр эрхлэх сонирхол давамгайлж байгаатай холбон тайлбарлаж болохоор байна.



Дүрслэл 2. “Төгсөгчдийн ажил эрхлэлт, хөтөлбөр тус бүрээр”



Гадаад хэлний орчуулга, Багш, гадаад хэлний боловсрол мэргэжлээр төгссөн төгсөгчид мэргэжлээрээ ажиллахгүй байгаа нь орон нутагт тус мэргэжлийн эрэлт хэрэгцээ бага, нөгөө талаас төгсөгчдийн ур чадвартай холбоотой байна. Цаашид тус 2 мэргэжлийн хөтөлбөрт анхаарал хандуулж, гадаад болон дотоод орчны шинжилгээ, үнэлгээ хийх шаардлага үүссэн байна.

Бид аудитын явцад тус сургуулийг Нягтлан бодогч, Газрын тосны инженер, Мэдээллийн технологи, Багш, сургуулийн өмнөх насны боловсрол, Багш, урлагийн боловсрол, Багш, бага ангийн боловсрол, Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол мэргэжлээр төгсөгчдийн дадлага, ур чадвар, харилцаа хандлагын талаар ажил олгогчидтой холбогдож, санал хүсэлтийг сонссон бөгөөд түүвэрт оролцсон 10 ажил олгогчдоос сөрөг хандлага нэг ч илэрхийлээгүй, харилцаа хандлага сайн, ажил мэргэжилдээ идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа талаар санал хүсэлтээ илэрхийлж байв.

Политехник коллеж

Тус сургуулийг 2017-2019 онд нийт 1234 оюутан төгссөнөөс 1-6 сарын дараа 45 хувь нь мэргэжлээрээ шууд ажлын байраар хангагдаж, 5 хувь нь дараагийн шатны сургуульд дэвшин суралцсан байна.

Бусад 627 төгсөгч буюу 50 хувь нь ажлын байраар хангагдсан эсэх талаар судалгаа бүрэн бус байна. ХНХЯ-нд хүргүүлсэн мэдээний дүн мөшгөх судалгааны дүнгээс зөрүүтэй байгаа тул бодит үр дүнг тооцох боломжгүй байна


Иймд БСШУС-ын 2010 оны 26 дугаар тушаал “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”-ын 2.4.7-д заасны дагуу төгсөгчдийн ажлын байрны судалгааг гаргаж, төгссөнөөс хойш 6 сарын болон нэг жилийн дотор ажлын байраар хэрхэн хангагдсан тухай судалгааг үнэн зөв, дэлгэрэнгүй гаргаж тайлагнаж байх нь зүйтэй байна.



Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв

Тус сургуулийг 2016-2020 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 538 оюутан төгссөнөөс 1-6 сарын дараа 74 хувь нь (үүнээс 51 хувь нь мэргэжлийн, 23 хувь нь мэргэжлийн бус ажил) ажлын байраар хангагдаж, 10 хувь нь дэвшин суралцаж, 16 хувь нь ажил эрхлээгүй байна.

Дүрслэл 3. “Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, мэргэжлийн салбараар 2017-2020 он”



Сургуулиудын захирлуудын үр дүнгийн гэрээний бодит гүйцэтгэл нь 81-88 хувьтай буюу хангалттай гэж дүгнэгдэхээр байгаа ч төгсөгчдийн ажлын байраар хангагдсан үзүүлэлт 70-аас доош хувьтай байгаа тул бодит үр дүнд анхаарч, төгссөний дараах ажлын байрны судалгааг үр дүнтэй, дэлгэрэнгүй байдлаар гаргаж, үнэн зөв тайлагнах нь зүйтэй байна.

1.2 Хүний нөөцийн төлөвлөлт, хуваарилалт, хөгжлийн хөтөлбөр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй байна.

Хүний нөөцийн төлөвлөлт нь байгууллагын эрхэм зорилго, стратегид нийцсэн гадаад дотоод хүчин зүйлүүдийн нөлөөллийг тооцсон, өөрийн байгууллагын онцлогт тохирсон байх шаардлагатай.

Дорнод их сургууль

Сургуулийн захирлын 2020 оны 04 дүгээр сарын А/29 дүгээр тушаалаар нийт 89,5 орон тоотой байхаар баталснаас гүйцэтгэлээр 74,5 орон тоотой ажиллаж, 15 ажлын байр дутуу байгаагийн 8 нь чөлөөтэй (жирэмсний өмнөх, дараах амралт), 7 нь эзэнгүй байна.

Хүснэгт 3. “Ажлын байрны судалгаа”

№	Алба, тасаг, нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Удирдлага	4	4	
2	Менежер	3	2	Сул 1, бүтэц өөрчлөгдөх
3	Эрүүл мэнд, туслах мэргэжилтэн	2	1	Сул 1
4	Багшлах мэргэжилтэн	36	33	Чөлөөтэй 2, 1 сул
5	Боловсролын арга зүйн мэргэжилтэн	14	9.5	Сул 1,5, чөлөөтэй 3
6	Бизнес, захиргааны мэргэжилтэн	2	1	Сул 1
7	Хууль, нийгэм соёлын мэргэжилтэн	3	3	
8	Конторын үндсэн болон туслах мэргэжилтэн	1	1	



Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн боловсролын болон их дээд сургуулиудын үйл ажиллагааны үр дүн

9	Тооцоолол материал бүртгэлийн ажилтан	1.5	1	Сул 0,5
10	Контторын бусад туслах ажилтан	6	6	
11	Хувийн үйлчилгээний ажилтан	3	1	Чөлөөтэй 1, сул 1
12	Барилга, түүнтэй холбогдох ажил, мэргэжлийн ажилтан	2	2	
13	Гар урлал, хэвлэлийн ажилтан	1.5	0.5	Чөлөөтэй 1
14	Цахилгаан, цахим техникч	0.5	0.5	
15	Жолооч хөдөлгөөнт төхөөргийн оператор	1	1	
16	Зах зээлд чиглэсэн ХАА-ны мэргэжилтэн	1	1	
17	Бусад энгийн ажилтан /Сахиул, манаач/	8	7	Чөлөөтэй 1
НИЙТ		89.5	74.5	


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын 1.2³ дахь заалтын дагуу багшаас бусад ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжил, боловсролын шаардлагыг хангаагүй 6 ажилтан байна. Үүнд:

Хүснэгт 4. “ДИС-ийн албан хаагчдын мэргэжил, боловсролын судалгаа”

№	Албан тушаал	Ажлын байрны тоо	Нийцээгүй шалтгаан
1	Номын санч	3	Боловсролын зэрэг магистр, түүнээс дээш гэж заасныг хангаагүй.
2	Хэвлэл мэдээллийн зохион байгуулагч	1	Боловсрол, мэргэжлийн шаардлага хангаагүй.
3	Нярав	1	Мэргэжлийн шаардлага хангаагүй.
4	Бакалаврын мэргэжилтэн	1	Боловсролын зэрэг магистр, түүнээс дээш гэж заасныг хангаагүй.
НИЙТ		6	

Боловсролын хувьд 1 хувь нь доктор, 52 хувь нь магистр, 25 хувь нь бакалавр зэрэгтэй байна. Бакалаврын хөтөлбөрийн хичээл ордог үндсэн багш нарын хувьд бүгд магистр зэрэгтэй байгаа ч зарим мэргэжлийн хичээл ордог дадлагажигч багш нар нь ажлын байрны шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Дүрслэл 4. “ДИС-ийн багш, ажилтнуудын ажилласан жил, боловсролын судалгаа”



³ 1.2.“Албан тушаалын тодорхойлолт” гэж тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын тусгай шаардлагыг баталгаажуулсан баримт бичгийг ойлгоно.




Дээд боловсролын тухай хуулийн 13.1⁴-д заасан магистр, докторын хөтөлбөрт хичээл орж буй багш нарын хүрэлцээ хангалтгүй байна. Тухайлбал тус сургуульд докторын зэрэгтэй мэргэжлийн багш 4 бүртгэлтэй ч ажиллаж байгаа нь 1 байгаа тул бусад их сургуулиудаас доктор, профессор багш нарыг урьж, магистр, докторын хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулж байна.

Багш, ажилтнуудын 33 хувь 3 хүртэлх жил, 44 хувь нь 5-аас дээш жил ажилласан байгаа нь харьцангуй тогтвор суурьшилтай байна.

Багш, ажилтнуудын хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2019 он 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу шинэчлээгүй байна.

Аудитын явцад сургуулийн үйл ажиллагаатай холбоотой санал асуулгад багш, ажилтнуудын 73 хувийг хамрууллаа.

Дүрслэл 5. “ДИС-ийн санал асуулгын дүн”



Санал асуулгад оролцогчдын 42 хувь нь сургуулийн орон тоо хэвийн хэмжээнд биш 46 хувь нь ажлын ачаалал их гэж хариулсан нь ажлын байрны зохион байгуулалтад анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

Дүрслэл 6. “ДИС-ийн Санал асуулгын дүн”



Санал асуулгад оролцогчдын 89 хувь нь хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр “хэрэгждэггүй-52”, “мэдэхгүй-37”, 47 хувь нь “Ажлын байрны тодорхойлолтод заагдсанаас өөр нэмэлт ажлыг гүйцэтгүүлдэг.” гэж хариулсан нь хүний нөөцийн

⁴ 13.1. Их сургууль, дээд сургууль, коллежид мэргэжлийн хичээлийг магистр, түүнээс дээш зэрэгтэй багш заах бөгөөд магистр, докторын хөтөлбөрийн хичээлийг докторын зэрэгтэй багш заана. Инженер, технологийн чиглэлээр сургалт явуулдаг коллежид мэргэшсэн инженер зааж болно



(нийгмийн баталгаа, сургалт) хөгжлийн хөтөлбөрийг батлуулаагүй, хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Мөн багш, ажилтнуудаас *ажиллагсдын ажиллах нөхцөлийг сайжруулах, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт нийгмийн баталгааг тусгах, багш нарын сургалт хөгжилд анхаарах, өгсөн өргөдөл, гомдлыг цаг хугацаанд нь шийдвэрлэдэггүй, удирдлага хоорондын уялдаа холбоо муу, санхүүгийн төлөвлөлт хангалтгүй байгаа талаар санал, гомдол ирүүлснийг ч анхаарах шаардлагатай байна.*

Дээрх судалгаа, шинжилгээ, санал асуулгыг дүгнэхэд хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулан батлуулж, үр дүнтэй хэрэгжүүлэх, нөөц бололцоондоо тулгуурлан батлагдсан орон тооны дагуу сул, чөлөөтэй орон тоог нөхөж, багш, ажилтнуудын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх асуудлыг нэн түрүүнд шийдвэрлэх шаардлага үүссэн байна.

Дорнод Политехник коллеж

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/21 дүгээр тушаалаар Дорнод Политехник коллежийн орон тоог 89 байхаар баталснаас гүйцэтгэлээр 81 орон тоотой ажилласан байна. Үүнд үндсэн багшийн орон тоо 6-аар дутуу, эмч, сүлжээ хариуцсан мэргэжилтний орон тоо тус бүр 1-ээр дутуу байна.

Хүснэгт 5. “Ажлын байрны судалгаа”

№	Алба, тасаг, нэгж	Төлөв-лөгөө	Гүйцэт-гэл	Тайлбар
Захиргаа, аж ахуйн алба				
1	Захирал	1	1	
2	Захиргаа, аж ахуйн менежер	1	1	
3	Ерөнхий нягтлан бодогч	1	1	
4	Нягтлан бодогч	1	1	
5	Нярав	2	2	
6	Захирлын туслах, бичиг хэрэг архив	1	1	
7	Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтан	1	1	
8	Хяналт шинжилгээ, мониторинг хариуцсан ахлах мэргэжилтэн	1	1	
9	ХАБЭА хариуцсан ахлах мэргэжилтэн	1	1	
10	Жолооч	1	1	
11	Слесарь, цахилгааны ажилтан	2	2	
12	Туслах ажилтан	1	1	
13	Бохирын үйлчлэгч	1	1	
14	Үйлчлэгч	8	9	
15	Жижүүр	6	5	
16	Мужаан	1	1	
Сургалтын алба				
17	Сургалтын албаны менежер	1	1	
18	Сургалтын албаны арга зүйч	1	1	
19	Багш	50	44	2 ангид элсэлт аваагүй.
20	Нийгмийн ажилтан	1	1	
21	Нийгмийн түншлэл, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, статистик хариуцсан мэргэжилтэн	1	1	
22	Цахим тоног төхөөрөмж, мэдээллийн сан, сүлжээ хариуцсан мэргэжилтэн	1	0	Багш хавсарч гүйцэтгэдэг. Жил бүр зарлаад ордоггүй.
23	Сургуулийн эмч	1	0	Чөлөөлөгдсөн. Намар зарлана.
24	Дотуур байрны багш	2	2	



25	Номын санч	1	1
	НИЙТ	89	81

Багшийн орон тоо 6-аар дутуу байгаа нь 2 мэргэжлийн ангид элсэлт аваагүйгээс шалтгаалсан байна. Сүлжээ хариуцсан мэргэжилтний ажлын байрыг жил бүр зарлан шалгаруулдаг ч тогтвор суурьшилтай ажилладаггүй байна. Эмчийн орон тооны хувьд 2020 онд өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөж шалгаруулалт зарлахаар төлөвлөгдсөн байна.

Ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжил, боловсролын шаардлагыг хангаагүй 7 албан хаагч байна.

Хүснэгт 6. “ПК-ийн албан хаагчдын мэргэжил, боловсролын судалгаа”

№	Албан тушаал	Ажлын байрны тоо	Нийцээгүй шалтгаан
1	Багш, бусад мэргэжлийн /Гагнуур д.д-70/	1	Гагнуурын багш байх гэсэн мэргэжлийн шаардлагыг хангаагүй.
2	Багш, металл судлал /д.д-71/	1	Бакалавр, Инженер багш байх гэсэн мэргэжил, боловсролын шаардлагыг хангаагүй.
3	Багш, бусад мэргэжлийн /д.д-72/	1	Бакалавр, Инженер багш байх гэсэн мэргэжил, боловсролын шаардлагыг хангаагүй.
4	Багш, физикийн /д.д-73/	1	Физикийн багш байх гэсэн мэргэжлийн шаардлагыг хангаагүй.
5	Багш, механикийн /токарь д.д-74/	1	Бакалавр, Токарийн багш байх гэсэн мэргэжил, боловсролын шаардлагыг хангаагүй.
6	Багш, механикийн /Үйлдвэрийн техникч д.д-76/	1	Бакалавр байх гэсэн боловсролын шаардлагыг хангаагүй.
7	Багш, механикийн /Инженер механик д.д-81/	1	Инженер механикийн багш байх гэсэн мэргэжлийн шаардлагыг хангаагүй.
	НИЙТ	7	

Мөн ажлын байрны тодорхойлолтыг боловсруулахдаа Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна. Тухайлбал: Газарзүйн багшийн албан тушаалын тодорхойлолтод мэргэжлийн шаардлагад “Ойн инженер мэргэжилтэй байх” гэж заасан нь тухайн мэргэжлээс зөрүүтэй байгаа бөгөөд 2 ажлын байрны тодорхойлолт байхгүй байна.

Хүснэгт 7. “Ажлын байрны тодорхойлолтын судалгаа”

№	Ажлын байрны нэр	Тоо	Тайлбар
1	Номын санч	1	Батлагдсан ажлын байрны тодорхойлолт байхгүй.
2	Туслах ажилтан	1	Батлагдсан ажлын байрны тодорхойлолт байхгүй.


Багш, ажилтнуудын /5 албан хаагчаас бусад/ хувийн хэргийг Төрийн албанын зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу шинэчлээгүй байна.

Албан хаагчдын 51 хувь нь бакалавр, 18 хувь нь магистр зэрэгтэй байна. Үүнээс үндсэн багш нарын 9 нь магистр, 31 нь бакалавр, 4 нь дипломын боловсролын зэрэгтэй байгаа нь нэг талаас Мэргэжлийн боловсролын сургалтын тухай хуулийн



18.1⁵ дэх заалтыг мөрдөж байгаа боловч, нөгөө талаас Дээд боловсролын тухай хуулийн 13.1⁶ дэх заалтын дагуу багшлах боловсон хүчнийг мэргэжил, боловсролын шаардлагад нийцүүлж, хөгжүүлэх зорилтыг бүрэн хангахгүй байна.

Дүрслэл 7. “Дорнод ПК-ийн багш, ажилтнуудын боловсрол, ажилласан жилийн судалгаа”



Багш, ажилтнуудын 81 хувь нь 3-аас дээш ажилласан нь харьцангуй тогтвор суурьшилтай ажиллаж байгааг харуулж байна.

Аудитын явцад сургуулийн үйл ажиллагаатай холбоотой санал асуулгад нийт багш, ажилтнуудын 93 хувийг хамрууллаа.

Дүрслэл 8. “Дорнод ПК-ийн санал асуулгын дүн”




Санал асуулгад оролцогчдын 28 хувь нь “Ажлын ачаалал их” гэж хариулсан нь ажлын ачаалал тохиромжгүй байх эрсдэлтэйг харуулж байна.

⁵ 18.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.

⁶ 13.1. Их сургууль, дээд сургууль, коллежид мэргэжлийн хичээлийг магистр, түүнээс дээш зэрэгтэй багш заах бөгөөд магистр, докторын хөтөлбөрийн хичээлийг докторын зэрэгтэй багш заана. Инженер, технологийн чиглэлээр сургалт явуулдаг коллежид мэргэшсэн инженер зааж болно



Дүрслэл 9. “Дорнод ПК-ийн санал асуулгын дүн”



Санал асуулгад оролцогчдын **35** хувь нь “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр хэрэгждэггүй-17 буюу мэдэхгүй-18”, **42** хувь нь “Ажлын байрны тодорхойлолтод заагдсанаас өөр нэмэлт ажлыг гүйцэтгүүлдэг” гэж хариулсан бөгөөд багш, ажилтнуудаас хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, багш нарыг сургаж, хөгжүүлэх, удирдлага, ажилтнууд хоорондын үл ойлголцол, уялдаа холбоог сайжруулах зэрэг санал, гомдлыг ажилтнуудаас илэрхийлж байсан.

Мөн 2019 онд баталсан хүний хөгжлийн бодлогын журам нь бодлогын баримт бичгийн шаардлагад нийцэхгүй, хэрэгжилт хангалтгүй байгаа тул сайжруулах шаардлага үүссэн байна.

Дээрх судалгаа, шинжилгээ, санал асуулгын дүнг дүгнэж үзвэл хүний нөөцийн бодлогын журам батлуулж хэрэгжүүлж байгаа боловч, хэрэгжилтийг сайжруулж, багш, ажилтнуудыг сургаж хөгжүүлэхэд анхаарах, батлагдсан орон тооны дагуу сул, чөлөөтэй орон тоог нөхөж, багш, ажилтнуудын ажлын ачааллыг багасгах, багш, ажилтнуудын хувийн хэргийг журмын дагуу шинэчлэн хөтлөх, зарим багш, ажилтныг ажлын байрны тодорхойлолтод нийцүүлж, мэргэжил, боловсролыг дээшлүүлэхэд анхаарах шаардлага үүссэн байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/21 дүгээр тушаалаар Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн орон тоог 50 байхаар баталснаас гүйцэтгэлээр 52 орон тоотой ажилласан байна.

Хүснэгт 8. “Ажлын байрны судалгаа”

№	Алба, тасаг, нэгж	Төлөв-лөгөө	Гүйцэт-гэл	Тайлбар
Захиргаа, аж ахуйн алба				
1	Захирал	1	1	
2	Захиргаа, аж ахуйн менежер	1	1	
3	Ерөнхий нягтлан бодогч	1	1	
4	Нягтлан бодогч	1	0	Ерөнхий нягтлан бодогч давхар хариуцдаг.
5	Нярав	1	1	
6	Захирлын туслах, бичиг хэрэг архив	1	1	
7	Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтан	1	1	
8	Хяналт шинжилгээ, мониторинг хариуцсан ахлах мэргэжилтэн	1	1	
9	Жолооч	1	1	
10	Сантехникч	1	1	



Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн боловсролын болон их дээд сургуулиудын үйл ажиллагааны үр дүн

11	Тогооч	1	1	
12	Туслах ажилтан	1	2	Гэрээт-Авто сервисийн ажилтан, Цахилгаанчин
13	Үйлчлэгч	3	4	Илүү 1
14	Жижүүр	4	4	
Сургалтын алба				
17	Сургалтын алба хариуцсан менежер	1	1	
18	Сургалтын албаны арга зүйч	1	1	
19	Багш	22	25	Гэрээт 1, Илүү 2 багш
20	Нийгмийн ажилтан	1	0	Намар 9 сард зарлана. Хүний нөөц давхар хариуцдаг.
21	Нийгмийн түншлэл, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, статистик хариуцсан мэргэжилтэн	2	2	
22	Цахим тоног төхөөрөмж, мэдээллийн сан, сүлжээ хариуцсан мэргэжилтэн	1	0	2020.04.01-нээс чөлөөлөгдсөн. Мэдээлэл зүйн багш нар чиг үүргийг давхар хариуцдаг.
23	Дотуур байрны багш	1	1	
24	ХАБЭА хариуцсан ажилтан	1	1	
25	Номын санч	1	1	
	НИЙТ	50	52	

Туслах нягтлан бодогч, Нийгмийн ажилтан, Цахим тоног төхөөрөмж, мэдээллийн сан, сүлжээ хариуцсан мэргэжилтний ажлын байр сул байгаа нь бусад давхар хариуцаж байгаа ажлын байранд ажлын ачааллыг үүсгэх эрсдэлийг үүсгэж байна. Багшийн орон тоо 3-аар илүү байгаа нь шинээр бэлтгэгдэж байгаа мэргэжилд нэмж багш авч ажиллуулсантай холбоотой байна.

Харин Захиргаа аж ахуйн албанд 1 туслах ажилтан /гэрээт/, 1 үйлчлэгчийн орон тоо илүү, сургалтын албанд 1 гэрээт багш, 2 үндсэн багшийн орон тоо илүү байгаа нь ХНХС-ын баталсан бүтэц, орон тооны тушаалыг баримталж ажиллаагүй байна.

Багш, ажилтнуудын хувийн хэргийн баяжилтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу шинэчилж, хөтөлсөн байна.

Албан хаагчдын 56 хувь нь бакалавр, 17 хувь нь магистрын зэрэгтэй байна. Үүнээс 24 үндсэн багш байгаагаас 19 нь бакалавр, 4 нь магистр, 1 нь докторын зэрэгтэй байна. Эдгээр багш, ажилтнуудын 33 хувь нь 3 жил хүртэл, 54 хувь нь 5-аас дээш ажилласан харьцангуй тогтвор суурьшилтай байна.

Дүрслэл 10. “МСҮТ-ийн багш, ажилтнуудын боловсрол, ажилласан жилийн судалгаа”






Аудитын явцад сургуулийн үйл ажиллагаатай холбоотой санал асуулгад багш, ажилтнуудын 54 хувийг хамрууллаа.

Дүрслэл 11. “МСҮТ-ийн санал асуулгын дүн”



Санал асуулгад оролцогчдын 30 хувь нь “Орон тоо хэвийн хэмжээнд биш”, 22 хувь нь “Ажлын ачаалал их” гэж хариулсан нь зарим мэргэжилтний орон тоо дутуу байгаагаас тухайн ажлын байранд ажлын ачаалал үүсэх эрсдэлтэйг харуулж байна.

Дүрслэл 12. “МСҮТ-ийн санал асуулгын дүн”



Санал асуулгад оролцогчдын 74 хувь нь “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр хэрэгждэггүй, мэдэхгүй”, 59 хувь нь “Ажлын байрны тодорхойлолтод заагдсанаас өөр нэмэлт ажлыг гүйцэтгүүлдэг” гэж хариулсан нь тус сургуулийн хүний нөөцийн (нийгмийн баталгаа, сургалт хөгжил) хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсанаас бусад удирдлагаас өгөх ажил, үүрэг их байгаагаар холбоотой байна.

Мөн багш, ажилтнуудаас орон тоог нэмэгдүүлэх, ажлын байрны тодорхойлолтод тохирсон ажил үүрэг гүйцэтгүүлэх, ажлын ачаалал их, хүний нөөцтэй холбоотой бодлого дутмаг, өргөдөл, гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэх зэрэг санал, гомдол ирүүлснийг ч үйл ажиллагаандаа анхаарах шаардлагатай байна.

Дээрх судалгаа, шинжилгээ, санал асуулгын дүнг дүгнэж үзвэл хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, батлагдсан орон тооны дагуу сул, чөлөөтэй орон тоог нөхөх, үндсэн багш нарыг батлагдсан орон тооноос хэтрүүлэхгүй байх, багш, ажилтнуудын ажлын ачааллыг тэнцвэржүүлэхэд анхаарах шаардлага үүссэн байна.



БҮЛЭГ 2. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1 Сургалтын хөтөлбөрүүд нь зохих стандартыг хангаж байна.

Дорнод их сургууль

Дээд боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Их сургууль, дээд сургууль, коллежийн сургалтыг хөтөлбөрт үндэслэн зохион байгуулах бөгөөд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сургуулийн Эрдмийн зөвлөл хэлэлцэж, сургуулийн захирал батлах бөгөөд сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.” гэж заасны дагуу Монгол улсын БСШУ-ны сайдын А/174 дүгээр тушаалаар батлагдсан бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан бакалаврын хөтөлбөрүүдийг дагалдах хичээлийн хөтөлбөрийн хамт баталгаажуулан сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Тус сургууль бакалаврын түвшний 19, магистрын түвшний 6, докторын түвшний 2, нийт 27 хөтөлбөртэй, 2024 онд хугацаа дуусах БСШУЯ-ны 960099 дугаар “Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл”-тэй байна.

Бакалаврын ангид элсэн суралцагч нь 4 жилийн хугацаанд 120 багц цагийн агуулга бүхий ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийг заавал судлах болон сонгон судлах хэлбэрээр судалдаг байна.

Дээд боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.12-т “Дээд боловсролын сургалтын байгууллага хөтөлбөрөө сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлүүлнэ,” гэж заасны дагуу ДИС нь 2017-2018 оны хичээлийн жилд Боловсролын магадлан итгэмжлэлийн зөвлөлөөр 3 хөтөлбөр магадлан итгэмжлүүлсэн байна. Үүнд багш, бага ангийн боловсрол 5 жилийн хугацаатай, багш, сургуулийн өмнөх насны боловсрол, нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрүүд тус бүр 1 жилийн хугацаатай магадлан итгэмжлэх эрх авсан байна.

Дээд боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.11-д “Дээд боловсролын сургалтын байгууллага боловсролын магадлан итгэмжлэл хийх эрх бүхий байгууллагаар байгууллагын магадлан итгэмжлэлийг заавал хийлгэнэ.” гэсэн заалттай.

Үүний дагуу магадлан итгэмжлүүлэх ажлыг зохион байгуулж, боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2019 оны 6 сарын 20-ны өдрийн 70 дугаар тогтоолоор тус сургуулийг 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэх тухай шийдвэр гарсан байна.

Политехник коллеж

Тус коллеж нь мэргэжлийн боловсрол болон техникийн боловсрол гэсэн төрлөөр сургалт явуулдаг. Хөдөлмөрийн сайдын А/197 дугаар тушаалаар батлагдсан чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвараар сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна. Сургалт эрхлэх зөвшөөрөл 18 мэргэжлээр 2022 он хүртэл сунгалттай байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 03 дугаар сарын 28-ны А/134 дүгээр “Техникийн боловсрол, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн загвар, шаардлага батлах тухай” тушаалаар 2019-2020 оны хичээлийн жилээс өмнөх элсэлтийг батлагдсан



төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу зохион байгуулж ажиллахыг политехник коллежийн захирал нарт үүрэг болгосон боловч тус коллеж одоог хүртэл сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөө шинэчлэн батлуулаагүй байна.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн GIZ төслийн дэмжлэгээр явагдаж байгаа үйлдвэрлэлийн техникч, аюулгүй ажиллагааны техникч гэсэн техникийн боловсролын 2 хөтөлбөрийг 1-2 жилийн хугацаанд шинэчлэх шаардлагагүй гэсэн зөвлөмжийн дагуу сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг шинэчлэх ажлыг хийгээгүй байна.

Нийт 5 техникийн боловсролын мэргэжлийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэх ёстойгоос малын бага эмч, зоотехникч, төлбөр, тооцоо, цалин хөлсний нягтлан бодогч гэсэн 3 мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг 2020 оны 6 дугаар сард багтааж батлуулахаар боловсруулсан байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв

Хөдөлмөрийн сайдын 2015 оны 10 дугаар сарын 19-ний А/197 дугаар тушаалаар баталсан Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загварын дагуу 14 мэргэжлийн 23 хөтөлбөрийг Зүүн бүсийн арга зүйн төвөөр хянуулж, дүгнэлт гаргуулан сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл нь 2022 он хүртэл сунгалттай хүчин төгөлдөр байна.

Тус сургууль нь боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 001 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт дахь “Боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”-ыг хангасан гэж үзэж, 2020 оны 6 дугаар сард байгууллагаа магадлан итгэмжлүүлэхээр ажиллаж байна.

2.2. Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний материаллаг орчин хангалттай хэмжээнд бүрдсэн байна.

Дорнод Их сургууль

Боловсролын тухай хуулийн 15.1-д “дээд боловсролын сургалтын байгууллага нь их сургууль, дээд сургууль, коллеж байна. Их сургууль нь эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн буюу эрдэм шинжилгээ-сургалтын, дээд сургууль нь сургалт-эрдэм шинжилгээний, коллеж нь сургалтын буюу сургалт-үйлдвэрлэлийн хэв шинжтэй байна.” гэж заасан байна.

Энэ нь их сургууль эрдэм шинжилгээ-сургалтын үйл ажиллагаанд илүү ач холбогдол өгөх ёстойг харуулж байна.

Тус сургууль нь сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажилд 2019 онд нийт төсвийн 4.3 хувийг төсөвлөж 0.8 хувийг л зарцуулсан байна.

Дээд боловсролын тухай хуулийн 5.6 дахь “Дээд боловсролын сургалтын байгууллага нь хамтарсан болон дагнасан сургалт, эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаа явуулах зориулалт бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний түшиц байгууллага, гарааны компани, лаборатори, эмнэлэг, дадлагын бааз, туслах аж ахуйтай байж болно.” гэсэн заалтын дагуу Дорнод Их



сургууль нь 2014 онд түшиц цэцэрлэг, Монгол судлалын зүүн бүсийн төв, 2015-2016 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын лицей сургуулийг байгуулсан байна.

Хэдийгээр судалгаа, эрдэм шинжилгээний ажилд сургуулийн төсвөөс бага зардал гаргасан хэдий ч БСШУ-ны яам болон бусад улс, орнуудын буцалтгүй тусламж, төсөл, арга хэмжээнд хамрагдаж, сургалтын орчин, судалгаа, эрдэм шинжилгээний материаллаг орчинг сайжруулахад сүүлийн 2 жилд 373.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийсэн байна.

Аудитын явцад нийт 54 ажиллагсдаас авсан санал асуулгын дүнгээс үзэхэд сургуулийн орчны материаллаг байдалд 62.9 хувь нь дунд гэсэн хариултыг өгсөн байна.

Санал асуулгын дүнгээс үзэхэд номын сангийн программ хангамж 2008 оноос хойш шинэчлэл хийгдээгүй, номын фондын баяжилт, анги танхимын тохижилт, хэвлэх цех, дадлагын бааз, лабораторийн техник хэрэгслийн шинэчлэлт дунд гэсэн байна. Боловсролын тухай хуулийн 16.1.1-д “Их сургууль, дээд сургууль, коллеж, түүний харьяаллын нэгжийн хичээлийн байр, номын сан, сургалт-эрдэм шинжилгээний лаборатори болон сургалтын бусад хэрэгслийг зохих журмын дагуу ашиглах эрхтэй” гэж заасныг мөрдлөг болгож, сургуулиас оюутнуудад дээрх чиглэлээр үйлчилгээ авах бүхий л нөхцөл боломжоор хангах үүргээ хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны санхүүжилтийг сургууль өөрийн эх үүсвэрээр буюу оюутны сургалтын төлбөрөөр санхүүжүүлж байгаа ба бусад эх үүсвэрийн санхүүжилт хайх, эрдэм шинжилгээний зардлын төсөвт эзлэх хувийг ихэсгэх бодлого барьж ажиллаагүй байна.

Политехник коллеж

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “MNS 6541:2015, Мэргэжлийн боловсрол, сургалт, ерөнхий шаардлага” стандартад “мэргэжил тус бүрээр сургалтын онолын танхим, дадлагын газар болон лабораторийг байгуулж, шаардагдах тоног төхөөрөмжийг суурилуулан гар багаж хэрэгсэл, сургалтын хэрэгслэгдэхүүн, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон анхны тусламжийн хэрэгслийг байршуулсан байх бөгөөд номын сан, соёл, спорт, судалгаа мэдээллийн танхимтай байна” гэж заасан байна.

Тус сургууль нь сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажилд 2019 онд нийт төсвийн 5.8 хувийг төсөвлөж зарцуулсан бол 2020 онд нийт төсвийн 5.8 хувь буюу 97.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

ХНХЯ болон бусад буцалтгүй тусламж, төсөл, арга хэмжээнд хамрагдаж, сургалтын материаллаг орчинг сайжруулахад сүүлийн 2 жилд нийт 195.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийсэн байна.

ХНХЯ-аас 2019 онд хийгдсэн хөндлөнгийн хяналтаар хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлтэй үнэлэгдсэн орчныг аюулгүй болгох гэсэн зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

Үүнд:

-Мэргэжлийн 7 ангийн дадлагын талбайг камержуулсан, дадлага, сургалтын орчинд тэмдэг тэмдэглэгээ, анхааруулах, тусгаарлах зурвасуудыг байршуулсан, сургалтын орчны гэрэлтүүлэг, агааржуулалтын системийг сайжруулсан байна.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох орчинг бүрдүүлэх үүднээс тусгай зориулалтын бариулыг шат болон ариун цэврийн өрөөнүүдэд хийсэн байна.



Аудитын явцад нийт 76 ажиллагсдаас авсан санал асуулгын дүнгээс үзэхэд сургуулийн орчны материаллаг байдалд 76.0 хувь нь сайн гэсэн хариултыг өгсөн байна.

Сургалтын орчинг сайжруулах зорилтын хүрээнд 2019 онд төлөвлөсөн сургуулийн гадна ЭКО “ОО” шинээр барьж эхлүүлэх, сургуулийн байруудын барилгын болон дээврийн засварыг мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх, дотуур байрны суралцагч хөгжүүлэх танхимыг шинэчлэн тохижуулах, мэдээллийг түргэн шуурхай хүлээн авах олон сувгийн телевизийг байршуулах гэсэн ажлууд хийгдэх байсан боловч санхүүжилт шийдэгдээгүй гэсэн шалтгаанаар бүрэн хэрэгжээгүй байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв

Тус сургууль нь сургалт, судалгаа, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 2019 онд нийт төсвийн 7.0 хувийг төсөвлөж 7.6 хувийг зарцуулсан бол 2020 онд нийт төсвийн 6.6 хувийг зарцуулахаар төлөвлөжээ.

2019 онд ХНХЯ болон бусад буцалтгүй тусламж, төсөл, арга хэмжээнд хамрагдаж, сургалтын материаллаг орчинг сайжруулахад 2019 онд 53.2 сая төгрөг, 2020 онд 144.5 сая төгрөг нийт 197.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийсэн байна.

ХНХЯ-аас 2019 онд хийгдсэн хөндлөнгийн хяналтаар сургалт, дадлагын орчны стандартын талаар дотуур байр, лаборатор, номын сангийн орчинг сайжруулах, сургалт, дадлагад ашиглаж байгаа техник хэрэгсэл, лаборатори, цех зэрэгт баталгаажуулалт хийлгэн дүгнэлт гаргуулах гэсэн зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

Үүнд:

- Дотуур байрыг 2019 онд хичээлийн төв байранд байрлах зориулалтын дотуур байранд нүүлгэн шилжүүлэлт хийж, орчин нөхцөлийг сайжруулсан байна.
- 2019-2020 оны хичээлийн жилд шинээр 15 компьютер бүхий лабораторийг ашиглалтад хүлээн авсан.
- Номын сангийн үйл ажиллагааг хэвийн явуулах тоног төхөөрөмжөөр хангасан байна.
- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төлөвлөгөөт шалгалт хийгдэж сургалт, дадлагад ашиглаж байгаа техник хэрэгсэл, лаборатори, цех зэрэгт баталгаажуулалт хийлгэн “Бага” эрсдэлтэй дүгнэлт гарсан байна.

Аудитын явцад нийт 27 ажиллагсдаас авсан санал асуулгын дүнгээс үзэхэд сургуулийн орчны материаллаг байдалд 74.1 хувь нь сайн гэсэн хариултыг өгсөн байна.

Сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа 14 мэргэжлийн анги багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

2.3. Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын хяналтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Мэргэжлийн боловсрол, сургалтын



тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.” гэж заажээ.

Дорнод аймаг дахь Мэргэжлийн боловсрол, сургалт байгууллагын дотоод хяналт нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-д нийцүүлэн гаргасан дотоод хяналтын журам болон бусад холбогдох эрх зүйн актаар зохицуулагдаж байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх дотоод хяналтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас нийгмийн түншлэл, батлагдсан бүтэц, орон тооны дагуу ажиллаж байгаа эсэх, ХНХЯ-наас өгсөн албан даалгавар, чиглэл, зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, багшлах боловсон хүчин, сургалт, дадлагын орчин, санхүүгийн үйл ажиллагаа, чанарын баталгаажилт гэсэн нийт 8 чиглэлээр хийсэн байна.

Дээрх хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдээс батлагдсан орон тоог хэтрүүлсэн зөрчилд зөвлөмж өгсөн байхад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/21 дүгээр тушаалаар орон тоог 50 байхаар баталсан байхад 2019 оны эцэст батлагдсан орон тооноос 7 хүнээр илүү ажиллуулсан байна.

Мөн аудитаар санхүүгийн зөрчил илэрч байгаа нь дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Энэ нь тус байгууллагын дотоод хяналт хариуцсан ажилтан болон нягтлан бодогч нь Төсвийн тухай хууль болон холбогдох хууль журмын мэдлэг хангалтгүй байгаатай холбоотой байна.

Хөндлөнгийн хяналтын хувьд аймаг дахь төрийн аудитын газраас 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна. Мөн аймгийн мэргэжлийн хяналтын газраас 2019 онд хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал чиглэлээр зөвлөн туслах төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

Политехник коллеж

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дорнод аймаг дахь Политехник коллежид нийгмийн түншлэл, батлагдсан бүтэц, орон тооны дагуу ажиллаж байгаа эсэх, ХНХЯ-наас өгсөн албан даалгавар, чиглэл, зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, багшлах боловсон хүчин, сургалт, дадлагын орчин, санхүүгийн үйл ажиллагаа, чанарын баталгаажилт гэсэн нийт 8 чиглэлээр дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дээрх хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдээс цалингийн санг зориулалт бусаар зарцуулсан, зарим сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг батлуулаагүй зэрэг зөрчил илэрсэн нь аудитаар давтагдан гарч байгаа нь дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байгааг харуулж байна. Тус байгууллагын дотоод хяналт хариуцсан ажилтан болон нягтлан бодогч нь ажлын хариуцлага болон холбогдох хууль журмын мэдлэгээ сайжруулах шаардлагатай байна.



Хөндлөнгийн хяналтын хувьд аймаг дахь төрийн аудитын газраас тус байгууллагын 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна. Мөн мэргэжлийн хяналтын газраас 2019 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу хүнсний бүтээгдэхүүний эрүүл аюулгүй байдлын чиглэлээр хяналт шалгалт хийгдэж, уг хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Дорнод их сургууль

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтын хувьд 2019 онд харьяалагдах дээд шатны байгууллага буюу БСШУСЯ-аас тус сургуульд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Тус сургуулийн дотоод хяналт хариуцсан ажилтан нь 2019 онд дотоод хяналтын төлөвлөгөө батлуулсан ч сүүлийн хагас жилд хяналтын талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна. Энэ нь дотоод хяналтын ажилтны орон тоо эзгүй байгаатай холбоотой байна.

Сургуулийн захирлын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/102 дугаар тушаалаар байгуулагдсан дотоод аудит, эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсэг нь сургуулийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитыг хийх ёстой боловч хийгээгүй байна.

Хөндлөнгийн хяналтын хувьд аймаг дахь төрийн аудитын газраас тус байгууллагын 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар сөрөг дүгнэлт өгөгдсөн байна. Харин мэргэжлийн хяналтын газраас 2019 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу тус сургуульд хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал чиглэлээр зөвлөн туслах хяналт шалгалт хийгдэж, уг хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ, САНХҮҮГ ҮР АШИГ, АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.

3.1.Төсвийн орлогыг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

Дорнод Их сургууль

Боловсролын тухай хуулийн 40.4.4-д “их сургууль, дээд сургууль, коллеж, политехник коллежид улсын төсөв, сургалтын төлбөр, эрдэм шинжилгээний төсөлт ажлын болон өөрийн үйл ажиллагааны орлого”, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 5.1-д “улсын төсвийн хөрөнгө, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилтэд зориулсан хөрөнгө, сургалтын төлбөр, гэрээт ажил, үйлчилгээ, аж ахуйн бусад үйл ажиллагаанаас олсон орлого, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хандив, тусламж, бэлэг, бусад эх үүсвэрээс бүрдэнэ” гэж заасан байна.

Дорнод Их сургуулийн орлого дараах эх үүсвэрүүдээс бүрдэж байна. Үүнд:

1. Улсын төсвөөс санхүүжилт
2. Үндсэн үйл ажиллагааны орлого
3. Туслах үйл ажиллагааны орлого




Боловсролын тухай хуулийн 40.2 дахь “..... өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашгийн болон ашгийн төлөө бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.” гэсэн заалтыг үндэслэн улсын төсвөөс тусгай шилжүүлгээр ахлах сургууль, цэцэрлэгийн ажилтнуудын цалин, хүүхдийн хоолны зардлын санхүүжилтийг Хэрлэн сумын төрийн сангаас олгож байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого нь их сургуулийн суралцагчдын сургалтын төлбөрийн орлогоос бүрдэж байна.

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36.12-т “Удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 36.12.4-д “сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтоох” гэж заасны дагуу Дорнод Их сургуулийн удирдах зөвлөл нь сургалтын төлбөрийн хэмжээг шийдвэрлэн тогтоож байна.

Тус сургууль нь 2018 онд нийт зардлын 70.1 хувийг сургалтын төлбөр эзэлж байсан бол 2019 онд 58.6 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж 11.5 хувиар буурсан байна. Энэ нь суралцагчдын тоо буурсантай холбоотой байна.

Дүрслэл 13. “Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл” (сая.төг)



Дорнод Их сургуулийн туслах үйл ажиллагааны орлого нь Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 5.1-д заасан эх үүсвэрүүд болох гэрээт ажил, үйлчилгээ, аж ахуйн бусад үйл ажиллагаанаас олсон орлого, бусад эх үүсвэрүүдээс бүрдсэн байна.

Туслах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 44.1.1 дэх “төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн байх” гэсэн заалттай нийцэхгүй байна. Санхүүгийн тайлангийн аудитаар уг зөрчлийг арилгах албан шаардлагыг өгсөн байна.



Хүснэгт 9. “Дорнод Их сургуулийн 2018-2020 оны хичээлийн жилийн туслах үйл ажиллагааны судалгаа” (сая.төг)

№	Үзүүлэлт	2018 он			2019 он			2020 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	ХБГ
1	Дотуур байр	42.7	39.2	-3.5	38.6	54.9	16.3	59.3	4.5
2	Цайны газар	50.0	43.8	-6.2	53.6	71.6	18.0	18.4	4.6
3	Зочид буудал	0.9	1.8	0.9	4.4	3.3	-1.1	5.2	0.02
4	Халуун ус	1.2	1.3	0.1	2.5	1.3	-1.2	1.6	
5	Канон					0.1	0.1	0.3	
6	Оюутны тооцоо	6.2	11.3	5.1	4.0	6.7	2.7	6.7	3.6
7	Спорт заал		3.2	3.2	11.6	8.6	-3.0	8.2	2.0
8	Гражийн түрээс	2.9	1.5	-1.4	0.6	0.0	-0.6	1.8	
9	Хэвлэх цех	10.0	17.6	7.6	15.1	14.0	-1.1	17.2	0.26
10	Гэрэл, ус	0	13.1	13.1	18.6	18.1	-0.5	20.2	8.6
11	Ромбо, дипломны орлого	7.2	8.4	1.2	7.9	7.3	-0.6	10.1	8.2
12	Оюутны бүртгэлийн хураамж	1.3	1.7	0.4	1.6	2.2	0.6	2.2	0.01
13	Архивын хураамж	0.2	0.2	0.0	0.2	0.2	0.0	0.2	0.04
14	Мал аж ахуй					16.3	16.3		
15	Ахлах сургуулийн төлбөр		55.1	55.1		57.0	57.0		
16	Төсөл, хандив, тусламж		10.0	10.0			0.0		6.79
17	Бусад	8.0	15.8	7.8	5.0	4.4	-0.6	10.3	1.4
	Нийт зардал	130.6	224.0	93.4	163.7	266.0	102.3	161.7	40.0

Дорнод Их сургууль нь туслах үйл ажиллагааны орлогод 2018 онд 130.6 сая төгрөгийг төлөвлөн, 224.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь 71.5 хувиар, 2019 онд 163.7 сая төгрөгийг төлөвлөн, 266.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь 62.5 хувиар тус тус давж биелсэн байна.

Дээрх судалгаанаас харахад орлого нь нийт дүнгээр төлөвлөснөөс давсан хэдий ч төрлийн хувьд харилцан адилгүй байна. Үүнд: 2018 онд гэрэл цахилгаан, спорт заал, төсөл, тусламж, ахлах сургуулийн төлбөр зэрэг орлогууд орсон бол 2019 онд мал худалдан борлуулсан, мөн ахлах сургуулийн хоолны төлбөрийн орлого зэрэг төлөвлөж болохоор орлогуудыг төлөвлөөгүй нь нөлөөлсөн байна.

Боловсролын тухай хуулийн 36.12.3 дахь “хөрөнгө оруулалт, жилийн төсвийн хуваарилалтыг баталж, зарцуулалтад хяналт тавих, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандив авах журам тогтоох”, ДИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.3 дахь “сургуулийн жилийн төсөв, хөрөнгө оруулалтын хуваарийг баталж, зарцуулалтад хяналт тавих” гэсэн заалтуудыг үндэслэн Дорнод Их сургуулийн удирдах зөвлөл нь “Лицей” ахлах сургуулийн хоолны зардлыг хурлаар баталж тогтоосон байна.

Боловсролын тухай хуулийн 39.3-т “Боловсролын сургалтын байгууллага санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх, багш, ажилтан, суралцагчийн нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжид нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж болох бөгөөд түүнээс олсон орлогоо энэ хуульд заасан зориулалтын дагуу захиран зарцуулах эрхийг боловсролын сургалтын



байгууллагын захирал, эрхлэгч эдэлнэ” гэж заасан боловч туслах үйл ажиллагааны үр дүнг тооцдоггүй, тооцоо судалгаатай бодитой төлөвлөдөггүйгээс хэрхэн үйл ажиллагаа, сургалтын орчинд үр нөлөө үзүүлж буйг нотлох нотолгоо алга байна.

Политехник коллеж

Политехник коллежийн орлого дараах эх үүсвэрүүдээс бүрдэж байна. Үүнд:

1. Улсын төсвөөс санхүүжих
2. Үндсэн үйл ажиллагааны орлого
3. Туслах үйл ажиллагааны орлого

2018-2020 оны төсвийн орлогын төлөвлөлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 10. “Орлогын төсвийн санал, төлөвлөгөө, гүйцэтгэл” (сая.төг)

Үзүүлэлт	2018 он			2019 он			2020 он		
	Төс- вийн санал	Төсөв	Гүйцэт- гэл	Төс- вийн санал	Төсөв	Гүйцэт- гэл	Төс- вийн санал	Төсөв	ХБГ
Улсын төсвөөс санхүүжих	1,864.5	1,421.3	1,366.5	1,738.1	1,642.6	1,565.6	2,085.7	2,007.5	619.5
Үндсэн үйл ажиллагааны орлого	35.0	45.8	57.5	36.8	50.8	68.8	50.8	50.8	12.7
Туслах үйл ажиллагааны орлого	9.0	9.0	0.6	9.0	9.0	0.0	9.0	9.0	0.0
Нийт орлого	1,908.5	1,467.1	1,424.6	2,012.4	1,702.4	1,634.4	2,145.5	2,067.3	632.2

ХНХЯ-аас ирүүлсэн чиглэл, төсвийн хязгаар, төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн дагуу 2019 оны улсын төсвийн төсөл, 2020-2021 оны төсвийн төсөөллийг хийж ХНХЯ-нд хүргүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого нь оюутны төлбөрийн орлогоос бүрдэж байна.

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36.12-т “Удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 36.12.4-д “сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтоох” гэж заасны дагуу Политехник коллежийн удирдах зөвлөл нь техникийн боловсрол олгох шатлан сургалтын төлбөрийн хэмжээг шийдвэрлэн тогтоож байна.

Дээрх хүснэгтээс харахад сүүлийн 3 жилийн төлөвлөлт нэмэгдээгүй боловч 2018, 2019 оны гүйцэтгэл төлөвлөгөөнөөс давсан байна.

Туслах үйл ажиллагааны орлого нь хадлан бэлтгэх орлогоос бүрдэхээр төлөвлөсөн байна.

Тус коллеж нь үндсэн үйл ажиллагааны орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн 2018 онд 45.8 сая төгрөг, 2019 онд 50.8 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс 2018 онд 57.5 сая, 2019 онд 68.8 сая төгрөгийн орлого оруулсан бол туслах үйл ажиллагааны орлогод 2018, 2019 онуудад нийт 18.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөж батлагдсан ч орлогын төлөвлөгөө



биелэгдээгүй байна. Энэ нь тухайн байгууллага хадлан эрхлэх тусгай зөвшөөрөлгүй байхад туслах үйл ажиллагаанд орлогыг төлөвлөсөнтэй холбоотой байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг 2018 оноос хойших төлөвлөлтийг үзэхэд тооцоо, судалгаатай төлөвлөөгүй байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв

Боловсролын тухай хуулийн 40.4.3-д “мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага улсын төсөв, өөрийн үйл ажиллагааны орлого”, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 22.1-д “улс, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө, гадаад улс, олон улсын байгууллагаас мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих зорилгоор олгосон зээлийн хөрөнгө, буцалтгүй тусламж, бусад эх үүсвэрээс бүрдэнэ” гэж тус тус заасан байна.

МСҮТ–ийн орлого дараах эх үүсвэрүүдээс бүрдэж байна. Үүнд:

1. Улсын төсвөөс санхүүжих
2. Туслах үйл ажиллагааны орлого

2018-2020 оны төсвийн орлогын төлөвлөлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 11. “Орлогын төсвийн санал, төлөвлөгөө, гүйцэтгэл” (сая.төг)

Үзүүлэлт	2018 он			2019 он			2020 он		
	Төс- вийн санал	Төсөв	Гүйцэт- гэл	Төс- вийн санал	Төсөв	Гүйцэт- гэл	Төс- вийн санал	Төсөв	ХБГ
Улсын төсвийн санхүүжилт	685.4	674.5	642.6	964.4	944.5	903.4	1098.7	1,089.6	741.2
Туслах үйл ажиллагааны орлого	8.5	8.5	8.4	8.5	8.5	5.8	8.5	8.5	0.7
Нийт орлого	693.9	683.0	651.0	972.9	953.0	909.2	1107.2	1,098.1	741.9

ХНХЯ-аас ирүүлсэн чиглэл, төсвийн хязгаар, төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн дагуу 2019 оны улсын төсвийн төсөл, 2020-2021 оны төсвийн төсөөллийг хийж ХНХЯ-нд хүргүүлсэн байна.

Туслах үйл ажиллагааны орлого нь түр сургалт болон дадлагын ажлын орлогоос бүрддэг байна.

Тус төв нь туслах үйл ажиллагааны орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн сүүлийн 3 жилд жил бүр 8.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс 2019 онд гүйцэтгэлийг хангаж ажиллаагүй байна.

3.2. Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв

Дорнод аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2019 онд 953.0 сая төгрөгийн батлагдсан урсгал зардлын төлөвлөгөөтэй ажилласнаас гүйцэтгэлээр 908.8 сая төгрөгийн зардал гаргасан байна.



Төсвийн зардлын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь графикаар харуулбал дараах байдалтай байна.

Дүрслэл 14. /мянган төгрөгөөр/



Нийт төсөвт урсгал зардал төлөвлөгдсөнөөс 44248.6 мянган төгрөг буюу 4.6 хувиар хэмнэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын бүлгийн дүнгээр нь шинжилж үзэхэд цалин хөлс болон нэмэгдэл урамшил 28492.5 мянган төгрөг буюу 4.8 хувиар, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 6376.9 мянган төгрөг буюу 8.6 хувиар, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 9154.2 мянган төгрөг буюу 10.9 хувиар, хангамж, бараа материалын зардал 176.7 мянган төгрөг буюу 1.4 хувиар тус тус хэмнэгдэж, бусад зардлын хувьд батлагдсан төсвийн хэмжээнд зарцуулсан байна.

Батлагдсан урсгал зардлаас хэмнэгдсэн шалтгааныг судалж үзэхэд цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл нь 2019 онд 2-3 албан хаагчийн ажлыг хавсруулан гүйцэтгүүлсэн, батлагдсан орон тоонд гэрээт ажилтан авч ажиллуулсан, улирлын үр дүнгийн урамшууллыг зохих хэмжээнээс харьцангуй бага хувиар тооцож олгосон зэрэгтэй холбоотой байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын хэмнэлт нь үйл ажиллагааны явцад үүссэн өөрийн барилгын халаалт, мөн барилгад цэвэр бохир усны шугамын хагарал үүссэнээс тодорхойгүй хугацаагаар усны тоолуур хаасантай холбоотой байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлийн нийт зардалд эзлэх хувь хэмжээг графикаар үзүүлбэл дараах байдалтай байна.



Дүрслэл 15.



Дээрх графикаас үзэхэд төсвийн гүйцэтгэлээр нийт зардлын 61.8 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, 7.4 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 8.2 хувийг тогтмол зардал, 6.9 хувийг хангамж, бараа материал, нормативт, эд хогшил, урсгал засвар, томилолтын зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 6.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 9.7 хувийг урсгал шилжүүлгийн зардал тус тус эзэлж байна.

Аудитын явцад төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж байгаа эсэхийг үзэхэд цалингийн зардалтай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тус сургуулийн захиралд 2019 онд улирлын ажлын үр дүнгийн урамшуулал болон мөнгөн шагналын нийт 2028.5 мянган төгрөгийг олгосон ч түүнийг томилох эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэр байхгүй байна.
- Байгууллагын бүх албан хаагчдад 2019 онд улирлын үр дүнгийн урамшуулал нийт 18879.6 мянган төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн ч тушаалаар баталгаажуулаагүй байна.
- Сахилгын шийтгэл хүлээсэн 2 төрийн албан хаагчид сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа нь дуусаагүй байхад 3, 4-р улирлын ажлын үр дүнгийн урамшуулал нийт 299.7 мянган төгрөгийг олгосон байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тушаалын 03 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.3, 4.7 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Мөн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 1640.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө /тавилга/-ийг зохих шийдвэргүйгээр бэлтгэсэн байна. Бусад урсгал зардлын хувьд үзэхэд хууль тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулсан байна.

Политехник коллеж

Дорнод аймаг дахь Политехник коллеж нь 2019 онд 1702.4 сая төгрөгийн батлагдсан урсгал зардлын төлөвлөгөөтэй ажилласнаас гүйцэтгэлээр 1634.4 сая төгрөгийн



зардал гаргасан байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Дүрслэл 15. /мянган төгрөгөөр/



Нийт төсөвт урсгал зардал төлөвлөгдсөнөөс 67994.8 мянган төгрөг буюу 4.0 хувиар зардал хэмнэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын бүлгийн дүнгээр нь шинжилж үзэхэд цалин хөлс болон нэмэгдэл урамшил 6436.2 мянган төгрөг буюу 5.9 хувиар, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 7288.9 мянган төгрөг буюу 5.4 хувиар, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 20580.6 мянган төгрөг буюу 12.8 хувиар, нормативт зардал 25086.8 мянган төгрөг буюу 26.6 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 4895.3 мянган төгрөг буюу 15.0 хувиар тус тус хэмнэгдсэн байна.


Батлагдсан урсгал зардлуудаас хэмнэгдсэн шалтгааныг судалж үзэхэд цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл нь 2019 онд 6-8 орон тоо дутуу ажилласантай холбоотой байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын хэмнэлт нь үйл ажиллагааны явцад үүссэн байна. Нормативт зардлын хэмнэлт нь дотуур байранд байрлах хүүхдүүдийн төлөвлөгдсөнөөс бага хүүхэд байрласнаас шалтгаалсан байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлийн нийт зардалд эзлэх хувь хэмжээг графикаар үзүүлбэл дараах байдалтай байна.



Дүрслэл 16. “Төсвийн гүйцэтгэлээр нийт зардалд эзлэх хувь”



Дээрх графикаас үзэхэд төсвийн гүйцэтгэлээр нийт зардлын 65.0 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, 8.0 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 9.0 хувийг тогтмол зардал, 9.0 хувийг хангамж, бараа материал, нормативт, эд хогшил, урсгал засвар, томилолтын зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 6.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 3.0 хувийг урсгал шилжүүлгийн зардал тус тус эзэлж байна.

Аудитын явцад төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж байгаа эсэхийг шалгахад цалингийн зардалтай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тус коллеж нь ажилтнуудын 2019 оны ээлжийн амралтын мөнгийг тооцохдоо хоол унаанд олгосон мөнгийг оруулж тооцсоноор нийт 7256.8 мянган төгрөг илүү олгосон.
- 2019 оны эхний хагас жилд бүх албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгосон байхад захирлын 2019 оны “Ажлын үр дүнгийн урамшуулал олгох тухай” А/49 дүгээр тушаалаар Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д “Төсвийн захирагч төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг төсвийн үр ашгийг сайжруулах зорилгоор тухайн төсвийн жилд захиран зарцуулж болно.”, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ын 2.2.3-д “ажилтан ажилчдын хөдөлмөр, бүтээлийг тодруулан алдаршуулах, хөдөлмөрийн алдар тэмдэглэх, шагнаж урамшуулах,” сургуулийн захирлын нийт багш ажилчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.4-д “Ажилтан албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэжлийн түвшинг үнэлж дүгнэх, урамшуулах” гэсэн заалтуудыг үндэслэн тус сургуулийн 95 жилийн ойг тохиолдуулан 2018-2019 оны хичээлийн жилд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэсэн үнэлгээ болон мэргэжлийн үр чадвар, идэвх санаачилга албан үүргээ тогтмол чанартай биелүүлсэн багш ажилчдыг хавсралтад заасан хувиар нийт 77 ажилтанд 30812.6 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас хавтгайруулан олгосон.
- Мөн оны 10 дугаар сард бүх албан хаагчдад 3 дугаар улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгосон байхад захирлын 2019 оны “Үр дүнгийн урамшуулал олгох тухай” А/80 дугаар тушаалаар Төсвийн тухай хуулийн Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ын 2.2.3-д “ажилтан ажилчдын хөдөлмөр, бүтээлийг тодруулан алдаршуулах, хөдөлмөрийн алдар тэмдэглэх, шагнаж урамшуулах,” гэсэн заалтыг үндэслэн сургуулийн түүхт 95 жилийн ойг зохион байгуулах, тэмдэглэн өнгөрүүлэх, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ISO 45001:2018 стандартыг хэрэгжүүлэх явцад хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу ажил үүргээ гүйцэтгэж, ёс зүйн зөрчил гаргаагүй зарим багш, ажилчдад хавсралтад заасан хувиар нийт 74 ажилтанд 11912.5 мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг хавтгайруулан олгосон.
- Оны эцэст бүх албан хаагчдад 4 дүгээр улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгосон байхад захирлын “Мөнгөн шагнал олгох тухай” А/110 дугаар тушаалаар Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах,” 46 дугаар зүйлийн 46.1-д “Төсвийн захирагч төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг төсвийн үр ашгийг сайжруулах зорилгоор тухайн төсвийн жилд захиран зарцуулж болно.”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид



шагнал олгох журам"-ын 3.3-д "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалин 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна." гэсэн заалтуудыг үндэслэн 2019-2020 оны хичээлийн жилд ISO 45001:2018 олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай ажилласан гэсэн шалтгаанаар цалингийн зардлаас нийт 81 ажилтанд 18000.0 мянган төгрөгийн мөнгөн шагналыг дахин олгосон байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах," 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэл тусгах, хяналт тавих журам"-ын 2.2-д "Төсвийн захирагчийн дараах зарцуулагдаагүй үлдээдлийг төсвийн зарлагын хэмнэлтэд тооцохгүй", 2.2.4-д "төсвийн байгууллага нь батлагдсан дээд хязгаараас дутуу орон тоогоор ажилласнаас бий болсон цалингийн зардал" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Бусад зардлын хувьд шалгаж үзэхэд төсвийн зардлыг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Урсгал зардлаас 1705.0 мянган төгрөгөөр үндсэн /процессор/ хөрөнгө зохих шийдвэргүйгээр бэлтгэсэн байна.
- Цалингийн зардлаас 3 ажилтанд 877.4 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон байна.
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 13854.4 мянган төгрөгийг өөрийн барилгын дээврийн засварт, 558.9 мянган төгрөгийг салбарын болон орон нутгийн шагналын дагалдах мөнгийг олгоход, өмнөх оны 12 сарын томилолтод 191.3 мянган төгрөгийг он гарсны дараа олгосон.
- Байгууллагын 95 жилийн ойн хүрээнд зүүн бүсийн мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудын дунд зохион байгуулагдсан бага хурлын үйл ажиллагааны хүрээнд хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 2400.0 мянган төгрөгийг хүлээн авалтын арга хэмжээнд, зарцуулсан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Тус байгууллагад батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулаагүй зөрчил гарч байгаа нь нягтлан бодогчийн Төсвийн тухай хууль болон холбогдох хууль журмын мэдлэг дутмаг байгаатай холбоотой байна.

Дорнод их сургууль

Төсвийн гүйцэтгэл нь төлөвлөгөөтэй уялдахгүй байгаа бөгөөд энэ нь 3 байгууллагын орлого, зардлын ажил гүйлгээнүүд нь зардлын ангиллаар тусдаа илэрхийлэгдээгүйтэй холбоотой байна. Төсвийн гүйцэтгэлийг 3 газраар салгаж харуулбал:

Хүснэгт 12. "Төсвийн гүйцэтгэл"

Зардлын тайлан	Их сургууль		Цэцэрлэг		Ахлах сургууль нийт төсөв		
	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан	Төлбөрөөс	Нийт дүн



Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн боловсролын болон их дээд сургуулиудын үйл ажиллагааны үр дүн

Нийт зарлагын дүн	1,433,963.2	1,305,492.2	185,368.8	191,124.8	87,044.1	57,215.0	144,259.1
Цалин хөлс нэмэгдэл урамшил	871,131.6	724,072.2	128,464.0	141,399.9	75,360.2	28,174.4	103,534.6
Ажил олгогч НДШ 12%	108,891.5	112,501.0	15,465.8	17,566.0	9,419.8	25,131.5	34,551.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	104,793.3	108,215.4	-	-			-
Хангамж бараа материалын зардал	70,664.4	64,835.7	1,073.6	517.1	1,890.7		1,890.7
Норматив зардал	45,090.0	66,016.0	38,265.4	30,793.3	27.6	50.7	78.3
Эд хогшил худалдан авах	81,260.1	35,375.1	500.0	238.4	-		-
Томилолт, зочны зардал	38,506.7	36,641.2	100.0	-	6.7	953.4	960.1
Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр	45,612.9	28,852.1	300.0	218.1	187.3	1,074.2	1,261.5
Бараа үйлчилгээний бусад зардал	61,172.7	117,741.6	1,000.0	392.0	151.8	1,830.8	1,982.6
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,840.0	11,241.9	200.0	-	-		-

Төсвийн гүйцэтгэлээр ДИС нь нийт 128,471.0 мянган төгрөгийн хэмнэлттэй харагдаж байгаа нь элсэгчдийн тоо төлөвлөсөн хэмжээнээс бага байсны улмаас оюутны төлбөрийн орлогын гүйцэтгэл 35.5 хувиар буурснаас шалтгаалж байна. Оюутны тоо төлөвлөсөн хэмжээнд хүргээгүйн улмаас үндсэн багшийн орон тоог багасгаж цагийн багш авч, илүү цагийн хөлсийг олгоогүйгээс цалин хөлс нэмэгдэл урамшлын гүйцэтгэлийг 147,059.0 мянган төгрөгөөр хэмнэлттэй харагдуулж байна.

Ахлах сургуулийн сурагчдын хоолны материалын зардлыг ДИС-ийн хоол хүнс зардлаар гаргасан нь норматив зардлын гүйцэтгэлийг хэтрэлттэй харагдуулж байна. Энэ нь ахлах сургуулийн сурагчдаас авах хоолны мөнгийг төлөвлөдөггүйтэй холбоотой байна.

2019-2020 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны явцад төсөл хөтөлбөрөөр орж ирсэн төслийн санхүүжилтийг бараа үйлчилгээний бусад зардлаар гаргасан нь гүйцэтгэлийг өсгөж харагдуулж байна. Энэ нь төсөл хөтөлбөрөөс орж ирэх санхүүжилтийг төлөвлөх боломжгүйтэй холбоотой байна.

Түшиц цэцэрлэгийн цалингийн төсвийн хэтрэлт нь төсөв нь цалин сандаа хүрэлцээгүйн улмаас норматив зардал болон бусад зардлын хэмнэлтээс цалингийн зардлаа нөхсөнтэй холбоотой байна.

- Тайлант хугацааны нийгмийн даатгалын тайлан болон цалингийн тооцооны баримтыг тулган үзэхэд 5,474.2 мянган төгрөгөөр зөрсөн бөгөөд энэ нь ажилтны нийгмийн даатгалыг төлсөн боловч цалингийн баримтад бүртгэлгүй, цалин олгоогүй байна. Уг ажилтан нь тус сургуулийн нийгэм хүмүүнлэгийн салбарын багш, доктор, дэд профессороор ажиллаж байгаад өөрийн хүсэлтээр, ДИС-



ийн захирлын 2017 оны 08 сарын 25-ны өдрийн Б/65 дугаар тушаалаар 2017-2018 оны хичээлийн жилд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөнбуйр дахь Багшийн их сургуульд багш солилцооны гэрээний дагуу монгол хэлний багшаар ажиллахаар томилогдсон байна. Уг гэрээнд үндсэн цалин болох 611.0 мянган төгрөгийг хөдөлмөрийн хөлс болгон авахгүй, зөвхөн нийгмийн даатгалын шимтгэлийг төлнө гэж заасан байна.

Үүнийг боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 26 тоот тушаалаар баталсан Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журмын 3.3-т “Үндсэн багшийн 15-аас доошгүй хувь нь докторын зэрэгтэй байна” гэж заасны дагуу докторын зэрэгтэй багшаа тогтоон барих зорилготой гэж тайлбарлаж байна. Энэ нь хөдөө орон нутагт докторын зэрэгтэй багш хангалтгүй, хөдөлмөрийн хөлс муу байгаатай холбоотой ч уг гэрээ нь хууль зүйн үндэслэлгүй байна.

ДИС-ийн захирлын 2018 оны 01-р сарын 10-ны Байгууллагын нийт багш ажилчдын сарын үндсэн цалингийн ангилал, зэрэглэл, шатлалыг шинэчлэх тухай Б/10 дугаар тушаалаар цалин олгож байна. Уг тушаалын үндэслэл болох Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын 3-р хавсралт нь Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 25 дугаар тогтоол гарснаар хүчин төгөлдөр бус болсон бөгөөд тушаалаа шинэчлэн батлаагүй байна.

- Дорнод их сургууль ажилтнуудын 2019 оны ээлжийн амралтын мөнгийг тооцохдоо хоол унаанд олгосон мөнгийг оруулснаас 1,708.8 мянган төгрөгийг илүү олгож арвилан хэмнэлтгүй зардал гаргасан байна.

Энэ нь Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2005 оны 5 дугаар сарын 5-ны 55 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох” журмын 4 дэх заалт “Ажилтанд олгож байгаа бүх төрлийнтэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого, /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй” гэж заасантай нийцэхгүй байна.

Тайлант онд 3 байгууллага арилжааны банкны тусдаа данстай боловч программ хангамж, регистрийн дугаар нэг байсан нь ажил гүйлгээг салгаж харахад хүндрэлтэй байсан бол Төрийн аудитын газрын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тусдаа хуулийн этгээдүүд болж улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна.

Ахлах сургууль болон цэцэрлэгийн зардалд хуримтлагдсан элэгдэл тооцогдохгүй, бүх хуримтлагдсан элэгдэл болон байр ашиглалттай холбоотой зардлууд ДИС-д хамаарагдаж байна. Энэ нь хөрөнгө нь зөвхөн ДИС-ийн нэр дээр бүртгэлтэй учраас элэгдэл болон байр ашиглалттай холбоотой зардлуудыг салгах боломжгүйтэй холбоотой байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

Б.Давуудийн:
Аудитор
тайлан
тавьсан.
Аудитор
тайлан
г
үзсэн
хүний
хүний
түвшин
түвшин
түвшин

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛЫН ЯАМ
ДОРНОД АЙМАГ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН
СУРГАЛТ ҮЙЛДЭРЛЭЛИЙН ТӨВ

21063 Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4880, 7058-3335

Хөд. ор. 25 № 57

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Тус төвийн 2019 оны санхүүгийн тайланд
хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж,
төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах
болно.

ЗАХИРАГч  Н.ХҮРЭЛБААТАР

ATAISSR 210635735 9030726

2020.06.25 №57 тоотыг гарт нь хүргүүлэв.
Хөтлөх хэрэгт 01/6-д

D: /2020-on албан ёсоор
2020.06.25


 ДОРНОД АЙМАГ ДАХЬ
 ДОРНОД ИХ СУРГУУЛЬ
 21071, Чойбалсан, Дорнод аймаг
 Утас: 7038-4667, <http://info@dornod.edu.mn>
 2020.06.25 № 265
 тэнэй _____ -ны № _____ -г
 ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
 АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
 АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА
 Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж,
 Төлбөрийн акт, албан саардлагыг цаашид
 хэрэгжүүлж ажиллана.
 2020. Хүндэтгэсэн,
 ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
 ГҮЙЦЭТГЭГЧ  Э. УНДАРМАА

 9030727 2115111586



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

21073, Чойбалсан, Дорнод аймаг
Утас/Факс: 7058-4895, <http://www.doptc.mn>

2020.06.25 № 02/97
танай _____ -ны № _____ -Т

Тайлбар хүргүүлэх тухай

Тус сургуулийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын зөвлөмж, албан шаардлага, актыг хэрэгжүүлж ажиллана. Харин 60,7 сая төгрөгийн актын тухайд дараах тайлбар хүргүүлж байна. Үүнд:

Тус сургууль нь 2019 онд Олон Улсын ISO 45001:15000 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежментийн тогтолцооны стандартыг Монгол улсын хэмжээнд төрийн байгууллагуудаас анх удаа болзолыг хангаж гэрчилгээ авсан ба мөн сургуулийн 95 жилийн ой тохиосон. Энэ үйл ажиллагаанд олгосон мөнгөн шагнал, урамшууллыг нийт багш ажилчид ажил үүргийнхээ хүрээнд төлөвлөсөн ажлыг хийж гүйцэтгэхийн тулд үндсэн ажлаас гадуур илүү цагаар зайлшгүй ажилласан тул илүү цагийн хөлсийг мөнгөн шагнал болон урамшуулал хэлбэрээр цалингийн сангийн хэмнэгдсэн зардлаас гаргасан. Энэ нь нийт багш ажилчидыг урамшуулж багш ажилчидын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлснээр багш нарыг ажлын байранд татах үндэслэл болж байгаа гэж үзсэн. Манай сургууль 2019 онд 6-7 орон тоо дутуу ажилласан нь мэргэжлийн багш нарыг ажлын байранд урьсан зар тавьсан боловч ирэхгүй, ирсэн нь цалин хөлс бага гэдэг шалтгаанаар зарим ажилд орсон багш нар өөрийн хүсэлтээр ажлаас гарсан. Энэ хугацаанд ажиллаж байсан захирал Д.Энхжаргал нь 2019 оны сүүлд ар гэрийн гачигдлаар хүсэлт гаргасны дагуу ажлаас чөлөөлөгдсөн тул иймээс тус актанд тусгагдсан 60,7 сая төгрөгний нийт багш ажилчдад олгосон шагнал урамшууллын актыг албан шаардлага, зөвлөмж болгож өгөхийг Танаас хүсье.

Цаашид дээрхи зөрчилийг давтахгүй хууль журмын дагуу нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалдаа тусгаж ажиллах болно

Жич: Хавсралт 5.. хуудастай.

Хүндэтгэсэн:

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Б.Болортуул:

Манидаг, дахи сургалт
М-т манайгуурч явцуу-
лах, аудитын тайланг
нутаг. 2020.06.25/2020.



210519263



ХАРИУ ТАЙЛБАР:

1. Ажилтнуудад 2019 оны 2, 3 дугаар улирлуудад нийт 42,725.1 мянган төгрөгийн урамшууллыг хавтгайруулан олгосон зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчид үүрэг болгохоор өөрчлөлт орууллаа.

2. Политехник коллеж нь 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/80 дугаар “Үр дүнгийн урамшуулал олгох тухай” тушаалаар Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ISO 45001:2018 стандартыг хэрэгжүүлэх явцад хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу ажил үүргээ гүйцэтгэсэн нийт 74 ажилтанд 11912.5 мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон байхад мөн дээрх нөхцөлөөр цалингийн зардлын хэмнэлтээс нийт 81 ажилтанд 18,000.0 мянган төгрөгийн мөнгөн шагналыг 2019 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн А/110 дугаар тушаалаар давхардуулан олгосон тул төлбөрийн актыг хэвээр үлдээлээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Үйл ажиллагааны бодит үр дүн буюу төгсөгчдийн ажил эрхлэлтэд анхаарах шаардлагатай байна.
2. Хүний нөөцийн бодлого, хөгжлийн хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт хангалтгүй байна.
3. Сургалтын хөтөлбөр зохих стандартыг хангаж байна.
4. Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний материаллаг орчин хангалттай хэмжээнд бүрдсэн байна.
5. Байгууллагын үйл ажиллагаанд хийж буй дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байна.
6. Төсвийн орлогыг бодитой тооцож төлөвлөөгүй байна.
7. Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.

Аудитаар нийт 124.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 31.7 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт, 78.0 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 15.0 сая төгрөгийн зөрчилд 18 зөвлөмж өгч ажиллалаа.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Дорнод Их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Э.Ундармаад:

1. Стратеги төлөвлөгөөний тухайн жилийн хэрэгжилтийг тайлагнах, үйл ажиллагааны төлөвлөгөөний бодит гүйцэтгэлд анхаарч, үр дүнг дээшлүүлэх.
2. Төгсөгчид нь мэргэжлээрээ ажиллахгүй байгаа нөхцөл байдалд гадаад болон дотоод орчны шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах.



3. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг сайжруулах.
4. Дотоод хяналтыг эрчимжүүлэх.
5. Орлогыг бодитой төлөвлөх.
6. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах.

**Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал
Н.Хүрэлбаатар:**

1. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний бодит гүйцэтгэлд анхаарч, үр дүнг дээшлүүлэх.
2. Төгсөгчдийн ажлын байрны дэлгэрэнгүй судалгааг нийт төгсөгчдөөр үнэн зөв, дэлгэрэнгүй гаргаж тайлагнах, ажлын байрны хангалтад дотоод, гадаад орчны шинжилгээ хийх.
3. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах.
4. Дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах.
5. Туслах үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж байх.
6. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах.

**Политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Т.Сүмбэрт:**

1. Стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулах, түүний хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний бодит гүйцэтгэлд анхаарч, үр дүнг дээшлүүлэх.
2. Төгсөгчдийн ажлын байраар хангагдсан талаарх судалгааг нийт төгсөгчдөөр үнэн зөв, дэлгэрэнгүй гаргаж тайлагнах, ажлын байрны хангалтад дотоод, гадаад орчны шинжилгээ хийх.
3. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг сайжруулах.
4. Дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах.
5. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж байх.
6. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 13

Чойбалсан хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн боловсролын болон их дээд сургуулиудын үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Дорнод Их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Э.Ундармаа, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Н.Хүрэлбаатар, Политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сүмбэр нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

110219'11



Дорнод аймаг дахь Төрийн аудиторын газрын
тэргүүлэх аудиторын 2020 оны 06 дугаар
сарын 25-ны өдрийн 44 тоот тушаалын хавсралт

Төлбөрийн актны жагсаалт

2020.06.25.

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн актны утга	Мөнгөн дүн /мян.төг/
1	Дорнод Их сургууль	ДОА-2020/05-ГА	Ээлжийн амралтын цалинг илүү тооцон олгосон	1,708.8
2	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	ДОА-2020/05-ГА	Томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй, сахилгын шийтгэлтэй ажилтанд урамшуулал олгосон	2,328.2
3	Политехник коллеж	ДОА-2020/05-ГА	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас хүлээн авалтын арга хэмжээнд зарцуулсан	2,400.0
4	Политехник коллеж	ДОА-2020/05-ГА	Ээлжийн амралтын цалинг илүү тооцон олгосон	7,256.8
5	Политехник коллеж	ДОА-2020/05-ГА	Мөнгөн шагнал, урамшууллыг давхардуулан олгосон	18,000.0
Нийт дүн				31,693.8

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Албан шаардлагын утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/
1	Дорнод Их сургууль	ДОА-2020/05-ГА	Багшлаагүй ажилтанд нийгмийн даатгалын шимтгэлийг төсвөөс олгосон	1,109.9
2	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	ДОА-2020/05-ГА	Тушаал шийдвэргүй үр дүнгийн урамшуулал олгосон	18,879.6
3	Политехник коллеж	ДОА-2020/05-ГА	Зардал хооронд гүйлгэн зарцуулсан	15,290.7
4	Политехник коллеж	ДОА-2020/05-ГА	Үр дүнгийн урамшууллыг хавтгайруулан олгосон	42,725.1
Нийт дүн				78,005.3



Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын 2-р байр, 1, 2 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn